



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2018 оны 01 сарын 29 өдөр

Дугаар А/44

Булган

Г Хөрөнгө гаргах тухай Г

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн хохирогч хүүхэд болон эмэгтэйчүүдийн эрх, аюулгүй байдлыг хамгаалах, хүүхдийг гэмт хэрэг, эрх зүйн зөрчил, хүчирхийлэлд өртөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор байгуулагдсан “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсүгэй.

2. “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 13440000 /арван гурван сая дөрвөн зуун дөчин мянга/ төгрөгийг орон нутгийн төсвийн нийгмийн хамгааллын ангилагдаагүй бусад зориулалт, арга хэмжээний зардлаас гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Наранжаргал/-д зөвшөөрсүгэй.

3. “Түр хамгаалах байр”-ны үйл ажиллагааг хэвийн явуулахад анхаарч, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга /Э.Түвшинмөнх/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ